



В. Шавар вааран эдлэлийг хэмжих дэс дараа


“Гоё сайхан биш, харин ч зөвөөр бич. Тэгэхгүй бол хойч үедээ зөвхөн балаг л үлдээнэ гэсэн үг.” Кобаяаши Юкио (1911-1988)




Шавар вааран эдлэлийг хэмжих тухай



Гурвалжин шугам хэрэглэж хээ угалзны зайг хувиарлах




1



2



3



4




5



6


Хэмжилт хийх дараалал

1. Шавар вааран эдлэлийн амсрын диаметрийг мэдье гэвэл нарийн хувиартай цаасан дээр шавар вааран эдлэлийг байрлуулна.
2. Шугамнууд хэрэглэж тухайн эдлэлийн хэлбэр дүрсийг хэмжинэ.
3. Нуман хэлбэрт шугамаар эдлэлийн гадаргуун тойргийн хэмжээг хэмжинэ.
4. Дээр хэмжсэнийгээ нарийн хувиартай цаасан дээр зурна.
5. Гортигон хэмжигчээр шавар вааран эдлэлийн зузааныг хэмжинэ
6. Хээ угалзны тохирох хэмжээгээр хэмжиж, хувиарлана.



Шавар вааран эдлэлийг хэмжих багаж

С. Шавар вааран эдлэлд хэмжилт хийж зурагласан бодит жишээ




006

HJ459—2 次(Сакю гожо шибо кюцүбо) 0015
 G0-89 P1 No. 7 20010628 Яёо-н үеийн шавар
 вааран эдлэл Богино хүзүүтэй ваар
 Амсрын диаметр 10.5cm Ваарын өндөр 24.8cm
 Ёроолын диаметр 4.2cm Хамгийн том бүслүүр
 хэсгийн диаметр 18.5cm
 Зуурмагийн чанар сайн, Болц сайн, (хар толботой)
 Өнгөний байдал:
 гадна тал Hue 2.5YR 6/4 (бүдэг улбар шар)
 дотор тал Hue 5YR 6/6 (улбар шар)
 зүссэн хэсэг Hue 7.5YR 5/2 (сааралтсан хүрэн өнгө)
 S=1/1 бүрэн дүрсэлсэн 20030819 Накажима

Анхааруулга (Шавар вааран эдлэлд хийсэн ажиглалт)

- Олдсон туурь, барилгын туурь, шавар вааран эдлэлийн дугаар, олдворлосон он, сар өдөр
- Шавар вааран эдлэлийн төрөл, эдлэлийн хэлбэр, эдлэлийн төрөл
- Амсрын диаметр, савны өндөр, ёроолын диаметр, хамгийн том бүслүүр хэсгийн диаметр
- Түүхий эд болох зуурмаг болон болцын байдал
- Өнгөний байдал
- Багтаамж, үлдэгдлийн байдал, жинхэнэ хэмжилт хийсэн он, сар өдөр, хэмжилтийг гардаж хийсэн хүн
- Урласан арга, боловсруулсан арга, хээний онцлог зэргийг хэмжиж, ажиглаж, баримтжуулах

D. Эдлэлийн хагархайнаас амсрын диаметрийн хэмжээг сэргээх




A-B, B-C тус тус цэгүүдийн дунд нь эгц босоо шугам татаж, тэнцүү хэсэгт хуваана. Тэдгээр 2 шугамын огтлолцол нь төвийн цэг болно.

[Анхаарах зүйлс]

-Шавар вааран эдлэлийн хазайлтыг шалгана.
-Амсрын диаметрийг шалгая гэвэл тойрог зураад түүн дээрээ эдлэлийг тавьж үзэн, сэргээсэн амсрын диаметр нь таарч байгаа эсэхийг шалгаж болно. (Шавар вааран эдлэлийн амсрын диаметр нь хэлбийсэн тохиолдол байдаг тул, заавал бүрэн тохирохгүй байж болно)

Төвийн цэгээс хамгийн анхны тэмдэглэсэн цэг хүртэлх нь диаметрийн тал нь болно

Төвийн цэг



D. Боловсруулах аргыг ажиглах болон илтгэх тухай



Хурууны мөр: -Хуруугаар дарсан мөр. Шавар вааран эдлэлийг гараараа нухаж хийсэн тохиолдолд, мөн эдлэлийн гадна талыг янзлах үедээ дотроос нь гараараа тулах зэрэгт гарын хээ үлддэг. Амсар, хүзүүний хэсэг болон шавар вааран эдлэлийн дотор талын үл мэдэг овгор товгорыг анхаарах хэрэгтэй.



Хясааны ясны хээний ором: -Сойзны үсний ором шиг паралель зураас үлдэх нь ихэнх тохиолдолд сойзныхыг бодвол зураас хоорондын зай нь өргөн, бас овгор товгор ихтэй байдаг. Зураасны эхэн хэсэгт хясааны ясны дугуйрсан ором үлдэх нь ч бий.



Сойзны үс: -Модны ширхэгийг бодвол олон паралель зураас үлддэг. Хэрэглэсэн банз (сойзны үс) -аас ялгааг нь харж болох ба банз (сойзны үс) ны өргөн, модны ширхэгийн тоог гаргаж болно.



Модон хутганы ором: Шавар вааран эдлэлийн гадаргууд ойрхон элсний ширхэг модон хутганы хөдөлгөөнөөр босох тохиолдол байдаг. Модон хутганы нэг удаагийн зураасны ором бүр нь ажлын багажныхыг бодвол өргөн мөр үлдээдэг. Удаа бүрийн хэмжээ болон чиглэл (элсний ширхэгийн нүүсэн чиглэл) -ийг анхаарах хэрэгтэй.



Модон хутганы хээ: Модон хутгаар хээлэгдсэн тал нь маш гөлгөр бөгөөд гялалзаж харагддаг. Нэг удаагийн хээлэх хэмжээ нь гэвэл, маш нарийн модон хутгаар олон удаа дарсан мөр харагдах нь олонтоо бий.



Цохилт: Банзанд сийлбэр хийж, түүгээр цохьсоноос үүсэх ул мөр. Паралель зураас, эсвэл дөрвөлжин зураас зэрэг нь олонтоо харагддаг. Шавар вааран эдлэлд ором үлдээхээр хэрэглэх нь олон ч, түүний дараах боловсруулалтаас болж арилж үгүй болох нь ч бий.